



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Боловсролын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СБА-2025/117/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баруун-Урт сум 2025 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Г.Даваа Утас: 70518396 Аудитын менежер: М.Нарантуяа Утас: 70512123 Аудитор: Б.Ганцэцэг Утас: 70512123</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

6 давхарт, Нутгийн удирдлагын 2 дугаар байр,
Балдан-Осорын гудамж, 7 дугаар баг,
Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг, 22075
Утас: (976) 70518396
Цахим шуудан: sukhbaatar@audit.gov.mn

2025.02.20 № 80

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсролын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгаар багш, албан хаагчдад зургаан сарын үндсэн цалинтай тэнцэх мөнгөн тэтгэмжийг улсын төсвөөс олгож эхэлснээр урсгал шилжүүлэг өмнөх онтой харьцуулахад 2 дахин нэмэгдсэн. Энэ нь төсвийн санхүүжилт нэмэгдэх шаардлагыг үүсгэж, сургалтын чанар, багш нарын хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах зохицуулалт болжээ.

Аудитын гол асуудал

Дээд шатны байгууллагаас төсөвт зохицуулалт хийж, батлагдсан төсөвт эрх олгож буй ажил гүйлгээ, хэрэгжүүлж буй арга хэмжээнд хангалттай хяналт тавихгүй байх нь санхүүжилтийн зориулалт зөрчигдөх, үр ашиггүй зарцуулалт гарах, төсвийн сахилга бат алдагдах эрсдэл үүсгэж болзошгүй байна. Иймд хийгдэх ажлын шаардлага, тоо хэмжээ, чанар, хэрэгжилтийг нарийвчлан хянаж, аудитаар тогтмол үнэлж байх шаардлагатай.

Бусад асуудал

Батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 3 зорилтын хүрээнд 60 арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилт “Хангалттай” буюу 97.3 хувь үнэлэгдсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Г.ДАВАА



ХОЁР. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>24,895,995.00</u>	<u>19,325,220.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	24,895,995.00	19,325,220.00
354	Хангамжийн материал	24,895,995.00	19,325,220.00
35410	Бичиг хэргийн материал	2,718,400.00	2,080,400.00
35420	Аж ахуйн материал	8,611,310.00	5,353,010.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	2,000,000.00
35440	Түлш, шатах тослох материал	560,000.00	270,000.00
35450	Барилгын засварын материал	1,857,700.00	1,908,200.00
35470	Бусад хангамжийн материал	11,148,585.00	7,713,610.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>201,021,689.74</u>	<u>166,878,586.59</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	201,021,689.74	166,878,586.59
392	Биет хөрөнгө	176,021,689.74	141,878,586.59
39201	Барилга, байгууламж, орон сууц	118,254,654.00	118,254,654.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(48,549,867.20)	(58,534,840.64)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	19,400,000.00	19,400,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(13,202,777.56)	(16,436,110.84)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	129,591,373.00	145,671,528.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(46,186,729.18)	(79,424,580.81)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,491,962.90	22,491,962.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	(7,815,169.22)	(11,582,269.02)
39217	Ном	2,038,243.00	2,038,243.00
393	Биет бус хөрөнгө	25,000,000.00	25,000,000.00
39301	Програм хангамж	300,000.00	300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(300,000.00)	(300,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	25,000,000.00	25,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>225,917,684.74</u>	<u>186,203,806.59</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,895,285.93</u>	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,895,285.93	-
413	Өглөг	1,895,285.93	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,895,285.93	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>224,022,398.81</u>	<u>186,203,806.59</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	224,022,398.81	186,203,806.59
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	124,596,298.00	124,596,298.00
51101	Өмч: - төрийн	124,596,298.00	124,596,298.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,266,324.41	(36,552,267.81)
51210	Өмнөх үеийн үр дүн	11,529,445.18	1,266,324.41
51220	Тайлант үеийн үр дүн	(10,263,120.77)	(37,818,592.22)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	98,159,776.40	98,159,776.40
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>225,917,684.74</u>	<u>186,203,806.59</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,729,898,248.50	5,203,330,703.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	72,975,108.50	14,694,786.00
120	Нийтлэг татварын бус орлого	72,975,108.50	14,694,786.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	72,970,108.50	14,694,786.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	72,970,108.50	14,694,786.00
120009	Бусад орлого	5,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,656,923,140.00	5,188,635,917.70
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,581,878,500.00	5,125,762,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,581,878,500.00	5,125,762,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	75,044,640.00	62,873,817.70
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,000,000.00	25,882,017.70
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	71,044,640.00	19,711,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	17,280,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,740,161,369.27	5,241,149,295.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,740,161,369.27	5,241,149,295.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	728,425,401.53	1,001,012,260.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	437,272,054.29	673,740,824.36
210101	Үндсэн цалин	248,457,868.97	373,107,968.25
210102	Нэмэгдэл	79,332,798.44	154,111,890.43
210103	Унаа хоолны хөнгөлөлт	56,234,000.00	88,515,665.68
210104	Урамшуулал	53,247,386.88	58,005,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,723,343.85	83,937,139.71
210201	Тэтгэврийн даатгал	36,959,607.17	57,762,256.69
210202	Тэтгэмжийн даатгал	4,357,877.93	6,680,319.34
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,486,302.24	3,340,159.63
210204	Ажилгүйдлийн даатгал	810,868.85	3,230,880.79
210205	Эрүүл мэндийн даатгал	8,108,687.66	12,923,523.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,026,300.00	47,719,600.00
210301	Гэрэл, цахилгаан	1,753,940.00	2,338,867.30
210302	Түлш, халаалт	42,617,850.00	42,168,182.70
210303	Цэвэр, бохир ус	1,654,510.00	3,212,550.00
2104	Хангамж, бараа материалын зардал	79,570,630.50	20,865,085.00
210401	Бичиг хэрэг	3,551,965.00	4,715,000.00
210402	Тээвэр, шатахуун	11,327,940.00	4,160,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	239,360.00	158,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	200,157.00	4,166,900.00
210408	Бараа материал акталсны зардал	2,612,700.00	7,424,785.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	61,038,508.50	-
2105	Нормативт зардал	14,370,700.00	16,399,555.00

210502	Хоол, хүнс	14,370,700.00	16,399,555.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,293,500.00	48,679,867.30
210604	Урсгал засвар	3,293,500.00	48,679,867.30
2107	Томилолт, зочны зардал	42,440,600.00	16,796,200.00
210702	Дотоод албан томилолт	42,440,600.00	16,796,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	452,733.05	27,429,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	452,733.05	27,429,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	51,275,539.84	65,444,489.15
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,901,410.00	11,092,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,335,539.00	5,514,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	43,038,590.84	48,837,889.15
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,011,735,967.74	4,240,137,035.40
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,936,557,785.00	4,151,743,180.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	826,937,587.00	1,061,620,480.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,107,930,198.00	3,086,972,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,690,000.00	3,150,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	75,178,182.74	88,393,855.40
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	75,178,182.74	88,393,855.40
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(10,263,120.77)</u>	<u>(37,818,592.22)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(10,263,120.77)</u>	<u>(37,818,592.22)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,656,928,140.00</u>	<u>5,188,635,917.70</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	5,000.00	-
120009	Бусад орлого	5,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,656,923,140.00	5,188,635,917.70
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,581,878,500.00	5,125,762,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,581,878,500.00	5,125,762,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	75,044,640.00	62,873,817.70
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,000,000.00	25,882,017.70
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	71,044,640.00	19,711,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	17,280,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>2,640,100,240.00</u>	<u>5,188,635,917.70</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,640,100,240.00	5,188,635,917.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	628,364,272.26	948,943,382.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	435,335,591.47	675,636,110.38
210101	Үндсэн цалин	248,185,595.85	373,246,254.27

210102	Нэмэгдэл	79,601,402.66	154,111,890.43
210103	Унаа хоолны хөнгөлөлт	56,095,714.07	88,515,665.68
210104	Урамшуулал	51,452,878.89	59,762,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,764,520.74	83,937,139.62
210201	Тэтгэврийн даатгал	37,000,784.06	57,762,256.60
210202	Тэтгэмжийн даатгал	4,357,877.93	6,680,319.34
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,486,302.24	3,340,159.63
210204	Ажилгүйдлийн даатгал	810,868.85	3,230,880.79
210205	Эрүүл мэндийн даатгал	8,108,687.66	12,923,523.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,026,300.00	47,719,600.00
210301	Гэрэл, цахилгаан	1,753,940.00	2,338,867.30
210302	Түлш, халаалт	42,617,850.00	42,168,182.70
210303	Цэвэр, бохир ус	1,654,510.00	3,212,550.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,147,278.00	6,753,100.00
210401	Бичиг хэрэг	2,387,135.00	1,098,500.00
210402	Тээвэр, шатахуун	11,887,940.00	3,870,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	239,360.00	158,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,032,843.00	1,386,200.00
2105	Нормативт зардал	14,370,700.00	16,399,555.00
210502	Хоол, хүнс	14,370,700.00	16,399,555.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,640,900.00	50,755,367.30
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,135,000.00	-
210604	Урсгал засвар	3,505,900.00	50,755,367.30
2107	Томилолт, зочны зардал	42,440,600.00	16,796,200.00
210702	Дотоод албан томилолт	42,440,600.00	16,796,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	452,733.05	27,429,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	452,733.05	27,429,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,185,649.00	23,516,810.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,263,610.00	14,459,510.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,922,039.00	9,057,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,011,735,967.74	4,239,692,535.40
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,936,557,785.00	4,151,298,680.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	826,937,587.00	1,061,620,480.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,107,930,198.00	3,086,528,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,690,000.00	3,150,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	75,178,182.74	88,393,855.40
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	75,178,182.74	88,393,855.40
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>16,827,900.00</u>	<u>-</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	16,827,900.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	16,827,900.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	16,827,900.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	16,827,900.00	-

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(16,827,900.00)	-
---	--	-----------------	---

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	124,596,298.00	98,159,776.40	11,529,445.18	234,285,519.58
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	124,596,298.00	98,159,776.40	11,529,445.18	234,285,519.58
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(10,263,120.77)	(10,263,120.77)
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	124,596,298.00	98,159,776.40	1,266,324.41	224,022,398.81
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	124,596,298.00	98,159,776.40	1,266,324.41	224,022,398.81
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	124,596,298.00	98,159,776.40	1,266,324.41	224,022,398.81
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(37,818,592.22)	(37,818,592.22)
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	124,596,298.00	98,159,776.40	(36,552,267.81)	186,203,806.59

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
12	Татварын бус орлого	5,125,762,100.00	5,037,620,333.29
12200	Тусламжийн орлого	5,125,762,100.00	5,037,620,333.29
122005	Төсвөөс санхүүжих	5,125,762,100.00	5,037,620,333.29
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,074,988,400.00	5,037,620,333.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,074,988,400.00	5,037,620,333.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	890,580,200.00	889,171,653.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	655,731,100.00	655,307,453.51
210101	Үндсэн цалин	388,931,800.00	360,267,722.98
210102	Нэмэгдэл	197,215,900.00	146,761,764.85
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,337,100.00	88,515,665.68
210104	Урамшуулал	38,246,300.00	59,762,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,963,500.00	81,415,362.48
210201	Тэтгэврийн даатгал	57,080,800.00	55,733,994.52
210202	Тэтгэмжийн даатгал	6,220,700.00	6,556,940.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,110,300.00	3,278,470.28
210204	Ажилгүйдлийн даатгал	3,110,300.00	3,169,191.44
210205	Эрүүл мэндийн даатгал	12,441,400.00	12,676,765.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,719,600.00	47,719,600.00
210301	Гэрэл, цахилгаан	1,583,900.00	2,338,867.30
210302	Түлш, халаалт	42,675,900.00	42,168,182.70
210303	Цэвэр, бохир ус	3,459,800.00	3,212,550.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,028,100.00	6,753,100.00
210401	Бичиг хэрэг	1,110,100.00	1,098,500.00

210402	Тээвэр, шатахуун	3,875,200.00	3,870,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	334,700.00	158,400.00
210404	Ном, хэвлэл	73,600.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	248,300.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,386,200.00	1,386,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	39,906,300.00	39,821,427.30
210604	Урсгал засвар	39,906,300.00	39,821,427.30
2107	Томилолт, зочны зардал	7,258,900.00	7,208,400.00
210702	Дотоод албан томилолт	7,258,900.00	7,208,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	27,444,200.00	27,429,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	27,444,200.00	27,429,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,528,500.00	23,516,810.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,468,300.00	14,459,510.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,060,200.00	9,057,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,184,408,200.00	4,148,448,680.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,096,789,300.00	1,061,620,480.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,086,988,100.00	3,086,528,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	630,800.00	300,000.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (I)	62,873,817.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	62,873,817.70
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	59,771,729.01
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	20,328,656.87
210101	Үндсэн цалин	12,978,531.29
210102	Нэмэгдэл	7,350,125.58
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,521,777.14
210201	Тэтгэврийн даатгал	2,028,262.08
210202	Тэтгэмжийн даатгал	123,378.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	61,689.35
210204	Ажилгүйдлийн даатгал	61,689.35
210205	Эрүүл мэндийн даатгал	246,757.52
2105	Нормативт зардал	16,399,555.00
210502	Хоол, хүнс	16,399,555.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,933,940.00
210604	Урсгал засвар	10,933,940.00

2107	Томилолт, зочны зардал	9,587,800.00
210702	Дотоод албан томилолт	9,587,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,102,088.69
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,850,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,850,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	252,088.69
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	252,088.69
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР (II)	62,873,817.70
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	62,873,817.70
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	62,873,817.70
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	25,882,017.70
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	19,711,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	17,280,000.00

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5 алдаа зөрчил илэрснээс, алдааг дахин давтан гаргахгүй байх 1 төлбөрийн акт, 3 албан шаардлага, 1 зөвлөмж өглөө.

3.1 Төлбөрийн акт

Хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт-1:

Аймгийн нийт сургалтын байгууллагын цалингийн мэдээлэлд үндэслэн дашибард боловсруулах ажил бүрэн хийгдээгүй, технологийн даалгавар батлагдаагүй, программ хангамж зохиогдоогүй, Power BI дээрх дата анализ шаардлага хангаагүй, зохиомж нь бүрэн бус байсан нөхцөлд гүйцэтгэл бүрэн хийгдсэн гэж үзэн 15,000.0 төгрөгийг шилжүүлсэн зөрчил дутагдал нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.2, 20.2.4, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.2.7, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12.2 дахь заалтуудыг зөрчсөн тул төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

Илрүүлэлт-1:

Элсэлтийн ерөнхий шалгалтад нийт онооны дунджаар улсын хэмжээнд дэд байр эзэлж амжилт үзүүлсэн албан хаагчдад 1,000.0 мянга, салбарын шагналаар шагнагдсан албан хаагчдад 500.0 мянга, нийт 1,500.0 мянган төгрөгийн шагнал урамшууллын зардлаас Хувь хүний орлогын албан татвар (ХХОАТ) суутгаагүй нь Татварын ерөнхий хууль болон холбогдох эрх зүйн актыг зөрчсөн байна. Дээрх шагнал, урамшуулал олгосон албан хаагчдаас мөнгөн дүнгийн 10 хувиар тооцож ХХОАТ-ыг суутган төсөвт төвлөрүүлж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт-2:

“Жаахан шаргын нутаг” монгол бичгийн уралдааны шагнал урамшуулалд зориулан өргөмжлөл, эрхийн бичгийг өндөр үнэ бүхий монгол ширэн бүтээгдэхүүнээр бэлтгэсэн нь

төсвийн хэмнэлт, үр ашигтай зарцуулалтын зарчимд нийцээгүй, зохистой бус худалдан авалт болсон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.2, 20.2.4, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.5 дахь заалтуудыг зөрчсөн тул зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлжээ.

Илрүүлэлт-3:

Төсвийн гүйцэтгэл, санхүүжилтийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэн тайлагнасны үндсэн дээр жилийн эцсийн санхүүгийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлтээр "Өөрчлөлтгүй" гэсэн дүгнэлт авсан тус байгууллагын дарга, нягтлан бодогчид 3 сарын, нярав, төсвийн мэргэжилтэн нарт 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.2, 20.2.4 дэх заалтуудыг зөрчсөн тул зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлжээ.

3.3 Зөвлөмж

Илрүүлэлт-1:

Тээвэр, шатахууны зарцуулалтын хяналт, үр ашгийг сайжруулах үүднээс албан ажлын автомашинд мэдээлэл, хяналтын төхөөрөмж байршуулж, ашиглалт, хяналтын үр дүн нэмэгдүүлэх шаардлагатай байна

Өгсөн зөвлөмж:

Албан ажлын автомашинд MNS 4598 стандартад заасан мэдээлэл, хяналтын төхөөрөмж буюу GPS суурилуулахад шаардагдах төсөв, хөрөнгийг дээд шатны байгууллагад хандаж шийдвэрлүүлэх

Дээрх төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуу		Хууль, хяналтын		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шагнал урамшууллын зардлаас ХХОАТ суутгаагүй	1	150.0			1	150.0							
Аймгийн нийт сургалтын байгууллагын цалингийн мэдээлэлд үндэслэн дашбоард бэлтгэх ажил хийгдээгүй	1	15,000.0	1	15,000.0									
"Жаахан шаргын нутаг" монгол бичгийн уралдааны шагнал урамшуулалд зориулан өргөмжлөл, эрхийн бичиг бэлтгэхдээ зах зээлийн ханшнаас өндөр үнээр худалдан авсан	1	9,750.0			1	9,750.0							
Төсвийн гүйцэтгэл, санхүүжилтийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэн тайлагнаж, жилийн эцсийн санхүүгийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлтээр "Өөрчлөлтгүй" дүгнэгдсэн байгууллагын дарга, нягтлан бодогчид 3 сар, нярав, төсвийн мэргэжилтэн нарт 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгосон	1	13,355.7			1	13,355.7							
Албан ажлын автомашинд мэдээлэл, хяналтын төхөөрөмж буюу GPS суурилуулаагүй	1	-					1	0					
Дүн	5	38,255.7	1	15,000.0	3	23,255.7	1	0					

ТАВ. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			